


The logo for the Asian Development Bank (ADB) is displayed in white serif font on a dark blue square background. The letters 'ADB' are prominently featured. To the right of the square, a thin vertical white line is present.

ADB

ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

АХБ-ны 9701 ТТ МОН төслийн зөвлөх
багийн ахлагч, Стратегийн худалдан
авалтын зөвлөх
А.Батбаяр



Source: Health financing strategy WHO 2010

БНЭМХ-ийн шалгуур ба үр дүн

Шаардлагатай тусламж,
үйлчилгээгээ авах

63 %

Хаана байх, хэзээ байхаас үл
хамааран авах

Хот хөдөөгийн ялгаа, тэгш бус байдал

Санхүүгийн бэрхшээлгүйгээр авах

Өрхийн орлогын хувь **2.39%**

6683 өрх ядууралд өртөх

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

ЭМ-ын Улсын зардал

Дотоодын нийт бүтээгдэхүүн

4% → 5%

Засгийн газар

10% → 12%

ЭМНЗ-д эзлэх хувь хүний төлбөр

36.4% → 25%

Анхан шатанд зарцуулах хэмжээг
ДЭМБ зөвлөмжид хүргэх

ДНБ 1%


ГОЛ МЕССЕЖ

Эрүүл мэндийн салбарын зардлын өсөлт нь эргээд хувь хүний шууд төлбөр буюу **ТАТВАР, ЭМД-ЫН ШИМТГЭЛ, ХУВЬ ХҮНИЙ ШУУД ТӨЛБӨР** буудаг учраас ямар үед ямар хэмжээгээр, ямар эх үүсвэрээр нэмэгдүүлэх вэ гэдэг нь чухал.


FIGURE 1.5 Out-of-pocket spending has declined across all income groups

Funding source share (% of total health spending)


Low income




Lower-middle income



Upper-middle income




High income




■ Government transfers
 ■ Social health insurance contributions
 ■ External aid
■ Voluntary health insurance contributions
 ■ Out-of-pocket spending
 ■ Other

Өндөр орлоготой улсын иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа илүү бага шууд төлбөр төлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ 2010-2018



ЭМДаатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээний нэр төрөл, санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр “Бодлогын шийдэл” тасралтгүй гаргаж ажилласан хэдий ч ... иргэний төлөх албан төлбөрийн хэмжээ буураагүй байгааг харуулж байна. /2016 онтой харьцуулахад 50% өссөн байгааг харуулж байна./



Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалт

8 дугаар зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.11.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, төсвийг төлөвлөх,

хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйл

24.3. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төлбөрийн жишиг хэмжээг Санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

24.5. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас төлбөрийн тусламж, үйлчилгээ үзүүлж олсон орлогыг хуульд нийцүүлэн эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд зарцуулахаар хуульчилсан

ЭМДҮЗ-ийн 01 тоот тогтоолын хавсралт /Журмын хавсралт 2. Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ/

2. Өндөр өртөгтэй шинжилгээний багцад хамаарах шинжилгээний жагсаалтыг ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ”-г баримтална.



ЧАНАР &
ҮР АШИГ

ӨМНӨХ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС АКТ, ЗӨРЧЛҮҮД



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 09 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 20/2021

Улаанбаатар-12
Утас 260817
Факс 976-11-310011

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай

Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваагийн 2021 оны 01/9264 тоот албан бичигт дурдсан асуудал Таны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байх тул харьяаллын дагуу шилжүүлэв.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам", "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хүчин төгөлдөр болоогүй байхад дагаж мөрдүүлсэн, түүнчлэн, хүчин төгөлдөр бус захиргааны уг актыг үндэслэн хуульд заасан хязгаарлалтыг зөрчиж, өндөр дүн бүхий төлбөрийн тариф тогтоон мөрдүүлж байгаа нь иргэдэд дарамт учруулахаас гадна авлига, ашиг сонирхлын зөрчил гаргах эрсдэлийг бий болгож байгаа тухай уг албан бичигт дурджээ.

Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актыг эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ." гэж, 67.3-т "Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй..." гэж тус тус заасан байх тул Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/228, 2020 оны А/436 дугаар тушаалаар баталсан журмыг хүчин төгөлдөр бус гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Иймд дээр дурдсан асуудлаар холбогдох тайлбарыг 2021 оны 9 дүгээр сарын 22-ны дотор ирүүлэх, хууль зөрчсөн захиргааны актыг хуульд нийцүүлэх, эсхүл хүчингүйд тооцох арга хэмжээ авч, дүнг нэг даруй эргэн танилцуулахыг мэдэгдье.

Хавсралт: ... хуудастай.

Хувийг: Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа танаа.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



[Signature]

Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Саяуны талбай 41, Утас: 1011-0251, Факс: 1076-1011-0251,
E-mail: oomong@gias.gov.mn, http://ias.gov.mn

2021.09.09 № 01/9264
талай _____-ийн № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН САЙД С.ЭНХБОЛД
ТАНАА


Авлигатай тэмцэх газар нь төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох, авлигын эрсдэл, шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгөх, арга зүйн тусалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмыг судлан үзэж, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй төлбөртэй тусламж, үйлчилгээний талаар дүн шинжилгээ хийхэд зарим байгууллагууд хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалт, тарифыг тогтоон мөрдүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан "төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт"-ыг зөрчиж, хууль тогтоомж болон дээд шатны байгууллага, албан тушаалтнаас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, түүгээр зохицуулсан харилцааг давхардуулан журамласан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/470 дугаар тушаалын хавсралтаар "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам", "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт", Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А/293 дугаар тушаалын хавсралтаар "Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-г тус тус батлан тэдгээрийг захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн даган мөрдөж байсан.

Гэтэл дээр дурдсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг 2016, 2020 онд тус тус шинэчлэн баталсан бөгөөд тэдгээр шийдвэрийг буюу Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны "Жагсаалт, журам батлах тухай" А/228 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны "Жагсаалт, журам батлах тухай" 36 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам", "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4-т заасны дагуу эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлээгүй байна. Үүний улмаас төлбөртэй тусламж, үйлчилгээний талаар нэгдсэн зохион

1. УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны Хуулийн өөрчлөлт болон ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоол батлагдаж хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагуудын төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг уялдуулан шинэчлэх зайлшгүй шаардлага бий болсон.
2. Ижил төрлийн оношилгоо, шинжилгээг өөр өөр тариф тогтоож ЭМД-аас нэхэмжилсэн, ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналт хийж санхүүжилтийг олгож чадахгүй хүлээгдэж байна.
3. Монгол улсын хэмжээнд хийгдэж буй оношлогоо, шинжилгээний мэдээний сан /дата/ байхгүй байна.
4. ЭМС-ын тушаалаар баталсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын жагсаалттай хоорондоо зөрдөг. /2015 оны А/470, 2016 оны ЭМС-ын А/228, 2020 оны А/436 тушаал/
5. Тарифгүй, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бодит зардлаар гэж тусгаж өгсөн нь байгууллага бүр өөр өөр тариф гаргаж мөрдөх, тэгш бус байдлыг дэмжиж байна.
6. Эрүүл мэндийн байгууллага бүр тус бүрдээ төлбөртэй тусламж, үйлчилгээний тушаал гаргаж мөрдөж байгаа нь төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг хяналтгүй тэлж байна. Жишээ нь Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах" 2017 оны 264/А/293 тушаалаар 475 оношлогоо, шинжилгээний жагсаалт баталсан байхад УНТЭ-ын захирлын тушаалаар 1078... гэх мэт өргөжүүлж хяналтгүй болгож байна. Эрүүл мэндийн байгууллагыг иргэнээс шууд төлбөр авах замаар орлого олох сонирхолыг төрүүлж байна.

АСУУДАЛ 

 ЭМД-аас тусламж, үйлчилгээнд **ЖИЛД 2 САЯ ТӨГРӨГ**


 Оношилгоо шинжилгээнд **САРД – 55 000 ТӨГРӨГ, УЛИРАЛД 165 000 ТӨГРӨГ**
ӨНДӨР ӨРТӨГТЭЙ МЭС ЗАСЛЫН ХЭРЭГСЛИЙН 25 ХУВЬ

 Хэрэгцээгүй оношилгоо, шинжилгээ ихэссэн



 Хязгаар нь дуусаад өвчтөн төлбөр төлдөг

ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ


ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ
7.1.8, 14.9.9 заалтуудыг хүчингүй болгож, дээд хязгааргүй болгосон



ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТЫН БҮТЭЦ



ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ОНОШИЛГОО ШИНЖИЛГЭЭ



Журамд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд төлбөртэй тусламж, үйлчилгээний тушаал гаргахдаа энэхүү тушаалаас өөр оношлогоо, шинжилгээний нэр төрөл, тариф нэмэхгүйгээр гаргаж мөрдөхыг тусгаж байгаа болно.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлсэн энэ хуулийн 24.6.10-т заасан тусламж, үйлчилгээнээс бусад тусламж, үйлчилгээний төлбөрийг тухайн иргэнээс авна.



2022 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг хоёрдугаар, "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж ажиллах, жагсаалтад тусгагдсан лабораторийн шинжилгээнд гадаад хяналт хийх лавлагаа лабораторийн жагсаалтыг батлуулахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар (Ж.Нарангэрэл)-т, эрүүл мэндийн урьдчилан үзлэг шинжилгээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагыг хамруулах тухай журмыг шинэчилж, хэрэгжилтэд хяналт тавьж аргазүйгээр хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Буянтогтох)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Жагсаалт, журам батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/470, 2016 оны А/228, 2020 оны А/436 дугаар тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.



С.ЭНХБОЛД

141213552

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот

ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-г нэгдүгээр, "Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг мөрдөж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг холбогдох журмын дагуу санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх орлогыг жил бүрийн төсөвт хянаж тусгахыг Эрүүл

мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар (Б.Мөнхтуул), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Буянтогтох), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай" Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264/А/293 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



САНГИЙН САЙД


Б.ЖАВХЛАН



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЭНХБОЛД

ИРГЭДЭД ОЙЛГОМЖТОЙ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ ӨГСӨН



Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	ЭМД-ын багцад хамаарах эсэх	Төлбөрийн жишиг хэмжээ
1	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Микобактери илрүүлэх болон РИФ тэсвэржилт тодорхойлох	10101001	Тийм	35,000
2	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Мөөгөнцөр илрүүлэх	10101002	Тийм	28,000
3	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Бичил биетэн өсгөвөрлөж, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (ш.арх, хамар, хамар залгиур, залгиур, чих, нүд, умайн хүзүү, шээсний сүв, үгрээ, өтгөн, идээ, буглаа, цэр, шээс, гуурсны арчдас (трахеостом, интубац, хэвлий, цээж, давсаг, ЭДВ-н болон бусад гуурс), хатгалтын шингэн, цэр бронхийн угаадасны нян судлалын шинжилгээ (хэвлий, плевр, тархи нугасны шингэн, үений шингэн, олгой цес))	10101003	Тийм	32,000
4	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Нян тээгчийн шинжилгээ	10101004	Тийм	30,000
5	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Шинжлэгдэхүүнийг будаж шинжлэх Граммын будгийн арга	10101005	Тийм	10,000
6	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Хүчилд тэсвэртэй нян өсгөвөрлөх	10101006	Тийм	21,000
7	Лабораторийн шинжилгээ	Бичил амь судлалын шинжилгээ	Хүчилд тэсвэртэй нян илрүүлэх түрхэцийн шинжилгээ	10101007	Тийм	15,000

ЭМДҮЗ 2022 оны 01 тогтоолын амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, хяналтын багц

ЭМДҮЗ 2022 оны 01 тогтоолын өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний багц

Мэдээллийн сан үүсгэж, тусламж, үйлчилгээний хэрэглээ, зарцуулалтад дүн шинжилгээ хийх

Иргэн төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөр болон ЭМД-ын хамтын төлбөрийг эмнэлэгт төлөхдөө төлбөр тооцооны бүхий л хэлбэрийг ашиглахаар зохицуулсан.

- Үүнд Касс болон цахим хэлбэрээр
- Төлбөр тушаах данс нь Төрийн сан дах Үндсэн үйл ажиллагааны данс байна.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХӨРӨД



ЗАСГИЙН ГАЗРЫН
СӨЛӨГӨӨДӨН АШИГТНИЙ
ТАТВАРЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



ГАЛ, ТӨМӨР, САХУУГИЙН
МЭДЭЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨМӨР

Иргэн та
валютаа солиулаад

И-БАРИМТАА АВНА УУ.

Харилцагч таны мэдээллийг иргэний
үнэмлэх шаардахгүйгээр хуруу уншигч
төхөөрөмж ашиглан баталгаажуулдаг
боллоо.

ХАРИУЦЛАГАТАЙ ИРГЭН ХЯНАЛТТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАГЧ ТА ТӨЛБӨРИЙН БАРИМТАА:



Хэвлэмэл
байдлаар



И-Баримт
аппликейшнээр



И-мэйл
хаягаар

Иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээнд И-баримтыг олгохоор зохицуулж өгсөн бөгөөд үүнд ЭМД-аас хэдэн төгрөг төлсөн, иргэн хэдэн төгрөг төлсөн гэдгийг нарийн тусгасан байна. Иргэний төлсөн төлбөр нь хамтын төлбөр болон төлбөртэй тусламж, үйлчилгээ нь ялгаатай байна.

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Нийт дүн
1	Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ	57,000₮	1	57,000₮
2	Өндөр өртөгтэй оношилгоо	120,000₮	1	90,000₮
	Үүнээс хамтын төлбөрийн дүн			30,000₮
3	Хэвтүүлэн эмчлэх	500,000₮	1	425,000₮
	Үүнээс хамтын төлбөрийн дүн			75,000₮
4	Төлбөртэй ор	20,000₮	7	140,000₮
5	Захиалгат хоол	5,000₮	3	15,000₮
	Нийт төлбөр			832,000₮
	ЭМД-аас төлсөн дүн			572,000₮
	Иргэний төлсөн дүн			260,000₮

ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛСЫН НЭГДСЭН
ДАТА САН БИЙ БОЛГОХ



ЭМНЭЛЭГ БҮР ЭМС, СС ХАМТАРЫН
ТУШААЛИЙН ХҮРЭЭНД ӨӨРИЙН
ТУШААЛЫГ ГАРГАНА



ЭМД-ЫН ЦАХИМ СИСТЕМ, БАГЦ,
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭТЭЙ
УЯЛДСАН

ГАДААДЫН ИРГЭДИЙН
ХУВЬД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ
АВАХ БОЛОН ТӨЛБӨР
ЗАЙЛШГҮЙ ТӨЛӨХ
ШААРДЛАГЫГ
ТОДОРХОЙЛСОН



НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭГ
ТОДОРХОЙ ЗОХИЦУУЛСАН

- ЭМД ОХБ-ын төлбөрийн хэмжээнд багтаагүй
- Тусламж, үйлчилгээний чанарт нөлөө үзүүлэхгүй
- Иргэн өөрөө сонгож авах боломжтой

The logo for the Asian Development Bank (ADB) is displayed in white serif font on a dark blue square background. A thin white vertical line is positioned to the right of the square.

ADB

A complex network of blue lines and dots is overlaid on the right side of the image, resembling a map of Mongolia or a data network. The dots are of varying sizes and colors, ranging from light blue to dark blue.

БАЯРЛАЛАА